

ЭНЭТХЭГ ДЭХ МОНГОЛ СУДЛАЛЫН ТАЛААР ӨГҮҮЛЭХ НЬ

*Доктор, профессор Б.Энхбаяр
/МУИС-ийн Олон Улсын
Харилцааны Сургууль/*

Энэтхэг судлалын төвөөс Энэтхэг улсын тусгаар тогтнолын өдөрт зориулан гаргаж буй энэхүү сэтгүүлийн анхны дугаарт өгүүлэл нийтлүүлэх боломж олгосон редакцийн зөвлөлийнхөнд баярласнаа илэрхийлье.

Монгол Энэтхэг хоёр улс бол түүх соёлын эртний уламжлалт харилцаатай, Азигийн өнө эртний өвөрмөц соёл иргэншилтэй улсууд билээ. Магай хоёр орны түүх соёл шашны харилцаа холбоо 2000 гаруй жилийн түүхтэй бөгөөд МЭӨ III зууны үеэс улбаатай нь түүхийн баримт сэлтээр нэгэнт тогтоогджээ. Энэтхэгээс гаралтай Бурхны шашин Түвд орноор дамжин Монгол нутагт орж ирснээр Монголчууд Энэтхэг орныг Жагарын орон, Бурханы орон хэмээн дээдлэн хүндэлж Энэтхэг орныг сонирхох болсон юм. Бүр МЭӨ III зуунд оршин тогтнож байсан төрт улс болох Хүннүгийн үед болон хожим XII-XIII зууны Их Монгол улсын үед ч Энэтхэгээс мөргөлч лам хуврага, худалдаачид Монгол нутагт ирж байсан тухай түүхийн баримт байдаг¹. Иймд Монгол судлал болон Энэтхэг судлалыг аль алины нь эртний уламжлалтай гэж үзэж болох талтай.

1955 онд Монгол Энэтхэг хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтсоны дараа соёлын хамтын ажиллагааны хэд хэдэн гэрээ хэлэлцээр байгуулагдсаны анхных нь 1961 оны Соёлын Солилцооны Хэлэлцээр бөгөөд хожим нь энэхүү хэлэлцээрийг 1978 онд шинэчилсэн билээ. Эдгээр гэрээ хэлэлцээрийн дагуу соёлын солилцооны хэд хэдэн хөтөлбөр хэрэгжиж энэ хүрээнд эрдэмтэн судлаач багш оюутан солилцох болсон нь чухамхүү тус тусын оронд Монгол болон Энэтхэг судлалыг шинжлэх ухааны үндэстэй хөгжүүлэхийн эхлэл болсон юм.

Миний бие 2001-2005 онуудад Жавхарлал Нэругийн их сургуульд Монгол судлалын зочин багшаар ажиллаж байсны хувьд Энэтхэг дэх Монгол судлалын сүүлийн үеийн байдлыг өөрийн уншиж мэдсэн, үзэж дуулсан дээрээ үндэслэн товчхон өгүүлэхийг хичээе.

Энэтхэг улс дахь Монгол судлалын асуудлыг их сургууль, судалгааны байгууллагын хэмжээнд болон хувь судлаач эрдэмтдийн хүрээнд гэж хоёр хувааж үзэж болно.

Өнгөрсөн жилүүдэд Энэтхэг дэх Монгол судлал болон манай хоёр орны эрдэмтдийн хамтын ажиллагаа амжилттай хөгжиж ирсэн билээ. Энэтхэг дэх Монгол судлалын эхийг тавих зорилгоор Энэтхэгийн эрдэмтэн Рагху Вира 1950-аад онд

¹ Г.Сүхбаатар. Монголын эртний түүх судлал. Монгол Нирун улс /330-555/. 3-р боть. УБ. 1992.133-р тал.

Монгол улсад хэд хэдэн удаа айлчилсан бөгөөд өөрийн үндэслэсэн Энэтхэгийн Соёлын Олон улсын академи дээр Монголын талаар судалгаа хийж эхэлжээ. Тэрээр 1959 онд Улаанбаатарт болсон Монгол судлалын Олон улсын анхны их хуралд оролцоходоо Ганжуур Данжуурын хөлгөн судар болон эртний Энэтхэг Монголтой холбоотой ном судрын зарим цуглуулгатай эх орондоо буцжээ.¹ Мөнхүү академи Монгол-Санскрит болон Санскрит-Монгол толь бичиг, Аржи Буржи болон Бигармижид хааны намтар, Бигармижид хааны үлгэр зэргийг хэвлүүлсэн байна.

Тус академийг өнөөдөр эрдэмтэн Р.Вирагийн хүү Профессор Локеш Чандра удирдаж байгаа бөгөөд Энэтхэг дэх Монгол судлалын нэгэн төв гэдгийг дурдах нь зүйтэй. Энэ академи Монгол судлал болон Монголын бурханы шашинтай холбоотой ном бүтээл хэвлүүлж олны хүртээл болгосны зэрэгцээ их эрдэмтэн гүүш Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, Ш.Бира нарын зэрэг Монголын нэртэй эрдэмтэд, судлаачидтай холбоотой ажилладаг байжээ.

Энэтхэгийн өнө эртний түүхтэй хотын нэгэн болох Варанасын их сургууль нь Монгол судлалын секцийг байгуулсан анхны институтийн нэг бөгөөд Өвөр Монголоос Галсан Лхүндэв хэмээх багш монгол хэл зааж байсан ба гарын авлага маягаар монгол хэлний жижиг толь бичиг гаргасан байна. Тэр секц 20-иод жил сургалт явуулаад багш болон шаардагдах сургалтын материалгүйн улмаас хаагдсаныг миний бие Дели хотод 2002 онд зохиогдсон нэгэн хурлын үеэр тэр сургуульд тухайн үед багшилж байгаад тэтгэвэртээ суусан нэгэн буурал эрдэмтэнтэй танилцахдаа олж мэдсэн билээ.

Мөн Энэтхэгийн баруун Бенгалийн Шантиникитан хотын Висва Бхаратийн их сургуульд монгол судлалаар ажилладаг багш нар цөөнгүй байсан байна. Хятад хэлний профессор Вэй Квэй Сэн хэмээх багш “Монголын Нууц Товчоо”-ны монгол хувилбар дээр үндэслэн “Монгол Гүрний нууц товчоон” гэсэн ном бичиж хэвлүүлсэн байна. Энэ сургуульд өвөр Монгол гаралтай Энэтхэгийн иргэн Лама Чимпа хэмээх Монголд элэгтэй нэгэн эрдэмтэн ажиллаж байсан тэрээр Монгол Түвдийн уран зохиолоор судалгаа хийдэг, монгол хэлэндээ маш хайртай бөгөөд Монгол-Англи ярианы жижиг толь бичиг зохиож хэвлүүлсэн байна. Проф. Лама Чимпа монгол хэл сурах эрмэлзэлтэй оюутан нилээд байсан ч ном сурах бичиг болон бусад шаардлагатай хангамж нөхцөл тааруу байсныг дурдсан байдаг.²

Энэтхэг улсын хэмжээнд Монгол судлалыг хөгжүүлж байгаа хамгийн том төв бол Жавахарлал Нэругийн Их Сургууль бөгөөд энд хоёр засгийн газрын хооронд байгуулагдсан албан ёсны гэрээ хэлэлцээрийн үндсэн дээр Монгол хэл болон Монгол судлалын хичээлийг заах болсон байна.

Тус сургуулийн Хэл соёлын сургууль дээр 1973 онд монгол хэлний салбар байгуулагдсан бөгөөд анхны зочин багшаар Хэл шинжлэлийн ухааны доктор /Sc.D/, академич Төмөртоогоо ажиллаж байжээ. Тэр цагаас арав гаруй багш монгол хэл заасан байна. Энэ салбар тус сургуулийн Япон болон Зүүн Хойд Ази судлалын

¹ O.Nyamdavaa. *Mongolia-India Relations. New Delhi. 2003. p.122.*

² *Mongolia and India: Spiritual Neighbours. Edited. O.Nyamdavaa. New Delhi. 2000. 96-p mal.*

төвд харьяалагддаг. Монгол хэлийг нэг жилийн сертификат олгох курс маягаар хичээллүүлж байгаа нь нэн чамлалттай бөгөөд цаашдаа диплом олгодог курс болгож өргөжүүлэн Монгол хэл заах зочин багшийг томилон ажиллуулах талаар Боловсрол Соёл Шинжлэх ухааны Яам нэгийг бодож даруй арга хэмжээ авмаар байна. Харин монгол хэлний сургалтыг хариуцдаг тус төв энэ сургалтыг тасалдуулахгүй явуулах талаар маш их анхаарал тавьж Энэтхэгт суугаа Монголын Элчин сайдын яаманд байнга хандаж байдгийг энэ дашрамд дурдмаар байна.

1989 онд Ерөнхий сайд асан Ж.Батмөнх тэргүүтэй төлөөлөгчдийн Энэтхэг улсад хийсэн айлчлалын үеэр мөнхүү Жавахарлал Нэругийн их сургуулийн Олон Улс Судлалын сургууль дээр Монгол судлалын салбар байгуулах шийдвэр гарснаар 1990-ээд оны эхнээс эхлэн монгол судлалын багш ажиллах болсон байна. Дээрх шийдвэртэй холбогдуулан Энэтхэгийн ерөнхийлөгч асан Р.Венкатраман “Манай Жавахарлал Нэругийн их сургууль дээр монгол судлалын салбар байгуулах шийдвэр гарч байгааг мэдэгдэхэд үнэхээр таатай байна. Энэ нь манай оронд Монголын баялаг өв соёл, түүний цаашид үргэлжилж буй олон талт ололт дэвшлийг судлахад маш том боломж олгоно гэдэгт би эргэлзэхгүй байна”¹ гэсэн юм.

Монгол судлалын салбар нь Нэругийн их сургуулийн Олон улс судлалын сургуулийн Зүүн Өмнөд, Төв Ази болон Номхон далайн бүс нутаг судлалын Төвд харьяалагддаг бөгөөд тэр цагаас дундаа завсарлагатайгаар 3 монгол багш зочин судлаач багшаар ажилласны сүүлийнх нь миний бие байлаа. Монгол зочин багш нар орчин цагийн Монголын улс төр, эдийн засаг, нийгмийн асуудлаар магистраас дээш түвшний оюутнуудад лекц уншихын зэрэгцээ Монгол судлалаар сэдэв сонгосон оюутнуудын ажлыг удирдана. Энэ төв дээр Монголын ардчилал, өөрчлөн байгуулалт, шинэ нийгэмтэй холбоотой асуудлаар хэд хэдэн оюутан боловсролын докторын зэрэг хамгаалсныг тэмдэглэхэд таатай байна.

Нэругийн их сургуульд Монгол судлалын салбар нээсэн явдал Энэтхэгийн монгол судлалын түүхэнд тэмдэглүүштэй том үйл явдал болсон агаад тэр цагаас хойш энэ сургууль монгол судлалын талаар судалгаа явуулдаг тэргүүлэх төдийгүй ганцхан газар болсон юм.

Хэдий тийм боловч монгол судлалыг цаашид хөгжүүлэхэд аль аль талын тавих анхаарал дутсанаас энэ судалгаа зохих төвшинд хүрч эрчимтэй явагдаж чадахгүй байгаа төдийгүй солилцооны хөтөлбөр ёсоор монгол зочин багш ажилладаг уламжлал нэгэнтээ тасраад байгаа нь нэн харамсалтай явдал билээ.

Монгол судлалыг сонирхон судалгаа шинжилгээ явуулж Энэтхэг оронд энэ ажлыг сурталчлахад хөдөлмөр оюунаа зориулсан, зориулж байгаа Энэтхэгийн Монгол судлаачдын талаар өгүүлэхэд таатай байна. Энд юуны өмнө Жавхарлал Нэругийн их сургуулийн геополитикийн профессор асан Р.С.Шарма, Рам Рахул, одоо тус төвийг тэргүүлж буй профессор С.С.Деора, Монгол судлалын салбар хариуцдаг профессор К.Варикуу, Төв Ази судлаач профессор Давааноров /Түвдийн цагаач/ нар монгол судлалыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсныг энд тэмдэглэмээр байна.

¹ O.Nyamdavaa. *Mongolia-India Relations. New Delhi, 2003. p.116.*

Төв Ази судлал түүн дотор Монгол судлалаар ажилладаг асан томоохон эрдэмтэн профессор Рам Рахул монгол судлалын салбарыг нээсэн анхдагчдын нэг юм. Тэрээр энэ салбарыг хөгжүүлэхийг дэмждэг байсан цөөхөн эрдэмтдийн нэг бөгөөд Төв Ази судлалд 1 сая. Монгол судлалын хөгжилд 1 сая рупийг /1 америк доллар тухайн үеийн ханшаас шалтгаалан 44-46 рупийтэй тэнцэнэ/ хувиасаа гарган хандивлаж асанг эдүгээ цөөхөн хүн мэднэ. Проф.Р.Рахул Монголыг Төв Азийн бүс нутгийн хүрээнд судалж "Хятад, ЗХУ-ын хоорондох Монгол улс", "Афганистан, Монгол ба ЗХУ" зэрэг нэгэн сэдэвт бүтээлүүдийг хэвлүүлж асан нэртэй монгол судлаач. Хоёрдох бүтээлдээ Монголыг Хятад Орос хоёр их гүрний дунд байрлах стратег талаас нь бүхэлд нь судалсан бөгөөд зөвхөн уламжлалт эх сурвалж ашиглаад зогсохгүй Монголд ирж өөрийн биеэр хийсэн судалгаан дээрээ үндэслэн номоо бичсэнээрээ Энэтхэгийн бусад монгол судлаачдаас давуу талтай юм.

Проф.К.С.Шарма 1990-2000 он хүртэл 10 илүү жил монгол судлалаар ажиллаж хэдэн арван өгүүлэл бичиж 2-3 эмхтгэл номыг хянан тохиолдуулснаас гадна Энэтхэг Монголын Найрамдлын Нийгэмлэгийн Ерөнхий нарийн бичгийн дарга, Олон Улсын Монгол судлалын Холбооны Гүйцэтгэх Хорооны гишүүн зэрэг сонгуультай эрдэмтэн байлаа. Тэрээр одоо өндөр насны тэтгэвэртээ сууж буй бөлгөө.

Мөн сургуулийн геополитикийн проф.С.С.Деора нь Монголд маш элэгтэй нэгэн бөгөөд Монгол улсыг Төв Азийн эртний нүүдлийн соёл иргэншилтэй, Төв Азийн шинээр тусгаар тогтносон бусад улсын хувьд түүх соёл тусгаар улсын хувьд туршлага болохуйц баялаг түүх уламжлалтай гэж онцгойлон үздэг эрдэмтэн юм. Тэрээр өөрийн нэгэн шавийг "Ази дахь гео-стратегийн өөрчлөгдөж буй дүр зураг: Монголын жишээн дээр" гэсэн сэдвээр докторын ажил хийлгэж байна.

Жавхарлал Нэругийн их сургуулийг Монгол судлалаар төгссөн цагаас үргэлжлүүлэн энэ салбарт судалгаа хийсээр байгаа залуу судлаач доктор С.К.Сонигийн бүтээлээс дурдахад Монголын улс төр, эдийн засаг, гадаад харилцаа, Монгол Энэтхэгийн харилцаа зэрэг сэдвээр олон арван судалгааны өгүүлэл бичсэний зэрэгцээ Монгол Оросын харилцаа, Монгол Хятадын харилцаа гэсэн бие даасан хоёр нэгэн сэдэвт зохиол бичиж нийтлүүлсэн ирээдүйтэй монгол судлаач юм.

Хоёр талын соёлын хэлэлцээр ёсоор Улаанбаатар болон Дели хотноо хэд хэдэн удаа хамтарсан эрдэм шинжилгээний хурал семинар зохиогдож түүнд манай хоёр орны төдийгүй бусад олон орны эрдэмтэн судлаачид оролцож монгол судлалын олон асуудлаар санал бодлоо солилцож байсан нь Энэтхэгийн монгол судлалын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулжээ. 1986 онд зохиогдсон коллоквиум нь манай эрдэмтдийн хамтын ажиллагаанд эрч хүч өгч түүнээс хойш 3 удаагийн эмхтгэлийг хэвлүүлсэн бөгөөд түүнд хоёр орны эрдэмтдийн Монгол Энэтхэг судлалын төрөл бүрийн асуудлаар бичсэн олон арван өгүүлэл нийтлэгдсэн байна.

Жавхарлал Нэругийн мэндэлсний 100 жилийн ойг тохиолдуулан хийсэн эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхтгэлийг 1997 онд Дели хотноо "Энэтхэг-Монгол: Харилцаа, Туршлага" нэртэйгээр ном болгон хэвлүүлжээ. Энэ нь 1988 онд

Улаанбаатарт болсон Монгол Энэтхэгийн 2-р хуралдааны үр дүн бөгөөд Монгол Энэтхэгийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааны үндсийг тавигч Жавхарлал Неруд үзүүлсэн хүндэтгэл байлаа.

1995 онд Дели хотноо Монголч эрдэмтдийн олон улсын анхдугаар бага хурал болсон нь Энэтхэгийн монгол судлалын түүхэнд чухал үйл явдал болсноос гадна энэ нь анх удаа Монголоос гадна өөр улсад болж олон орны эрдэмтдийг оролцуулснаараа онцлог байсан төдийгүй Энэтхэгийн эрдэмтдийг монгол судлал руу хандуулахад чухал хувь нэмэр болсон байна.¹ Энэ хурлын илтгэлүүдийг эмхтгэж ном болгосон ба хянан тохиолдуулагч нь профессор Р.С.Шарма байлаа.

Хамтарсан уулзалт семинарын үр дүн болж хэвлэгдсэн дээрх эмхтгэл, номуудад Проф.Локеш Чандра, К.С.Шарма, Б.Б.Лайер, Д-р К.С.Сони, Д-р.П.Стобдан зэрэг Энэтхэгийн бусад монгол судлаач эрдэмтдийн Монголын холбогдолтой төрөл бүрийн үнэ цэнэтэй өгүүллүүд нийтлэгдсэн байна. Үүний зэрэгцээ Монгол улсад Энэтхэг улсаас суух элчин сайдаар ажиллаж байсан болон улс төр нийгмийн зүтгэлтнүүд, Дэлхийн Банк, Дэлхийн Эрүүлийг Хамгаалах байгууллага болон бусад нийгэм, эдийн засаг, соёл, боловсролын шугамаар Монгол оронд ирж ажиллаж, амьдарч мөн богино хугацаагаар айлчилж байсан олон хүмүүсийн дурсамж дурдатгал дээрх эмхтгэлүүдэд нийтлэгдсэн нь Энэтхэг дэх Монгол судлалын ажилд эх хэрэглэгдэхүүн болох үнэ цэнэтэйг тэмдэглэх нь зүйтэй.

Эцэст нь Дорно Дахины судлалаар баялаг уламжлалтай энэ агуу орон Монгол улстай эртнээс нааш оюун санааны түүхэн харилцаатай байсны хувьд дэлхийн Монгол судлалын тэргүүлэх төв болоосой хэмээн хүсэж байгаагаа өгүүллээрээ дамжуулан илэрхийлье.

¹ *Mongolia: Tryst with Change and Development. New Delhi. 1997.*